

9

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ,
ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.12.12

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Биеийн тамир, спортын салбарын Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд эрх зүйн актын хэрэгжилтэд Монгол улсын тухай хууль, Улсын Их хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлаар санал, зөвлөмж боловсруулах Засгийн газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3-р зүйлийн 3.7 дахь хэсгийг удирдлага болгов.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын тогтоол 1 заалт, Засгийн газрын хуралдааны 3 тэмдэглэлийн 4 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 4 заалт нийт 9 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.

“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.7-д заасан аргачлалаар дүгнэхэд Биеийн тамир, спортын салбарын Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт **“хэрэгжсэн”** байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн, хүснэгт

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Гүйцэтгэлийн хувь
Засгийн газрын тогтоол			
1.	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	100%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл	III.2. Иргэдэд хоол, хүнсний илчлэг (калори)-ийн талаар ойлголтыг олгож зохистой хэрэглээг бий болгох, эртэч, бүтээлч, зэрэг, зөв хандлагатай эрүүл амьдралын хэмнэлийг бий болгох зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх	100%

2.	2022-11-09 Дугаар 2022_54	талаар хамтран шуурхай ажиллаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав	
	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 11/8/2023 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	100%
	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 4/3/2024 Дугаар 2024_13	22.4.2.. Олимп, паралимпын наадамд оролцох бэлтгэл хангах асуудлыг “Үндэсний хороо”-ны хуралдаанаар хэлэлцүүлэн саналаа нэгтгэж, шаардлагатай зардлын тооцоо, судалгааны хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин нарт	100%
		22.4.3.. Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулахад онцгой амжилт гаргаж, Азийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнээс хүрэл медаль хүртсэн Монгол Улсын сагсан бөмбөгийн үндэсний шигшээ баг (эрэгтэй, эмэгтэй)-т Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит мөнгөн шагналыг зохих журмын дагуу олгох арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэд, Соёлын сайд Ч.Номин нарт	100%
Засгийн газрын албан даалгавар			
3.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	1.12.. Эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх бодлогын реформыг хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин нарт;	100%
		19.6. 19.6.“Лос-Анжелес-2028” зуны олимпын стратеги боловсруулж, хэрэгжүүлж эхлүүлэх;	90%
		19.7. 19.7. Энэ албан даалгаврын 1.12-т заасан реформыг хэрэгжүүлэх хүрээнд биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэмжих чиглэлээр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх.	100%
	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан	27. 27. Албан даалгаварт туссан төсөл, арга хэмжээний ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнг иргэд, олон нийтэд таниулах, Засгийн газрын нэгдсэн тайлангийн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын	100%

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 9/18/2024 Дугаар 2024_01_1	20-ны өдөр зохион байгуулах, шаардлагатай бэлтгэл хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	
Хэрэгжилтийн дундаж 98,8% буюу “хэрэгжсэн”		

Гурав: Дүгнэлт

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ хийхэд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хүрээнд үр дүн “хэрэгжсэн” байна гэж дүгнэгдлээ.

Дөрөв: Санал, зөвлөмж

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024 оны 09 дүгээр сарыг 18-ны өдрийн Дугаар 2024_01_1 дугаар бүхий Засгийн газрын албан даалгаврын 19.6. 19.6.“Лос-Анжелес-2028” зуны олимпын стратеги боловсруулж, хэрэгжүүлж эхлүүлэх” заалтын хэрэгжилтэд анхаарч ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар, Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэст тус тус зөвлөмж хүргүүлж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА



Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.УРАНБИЛИГ